



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар Д/136

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймаг, Оросын Холбооны улсын Красноярск хязгаартай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд тус хязгаарын аялал жуулчлалын холбооны төлөөлөгчдийг хүлээн авах, Франц улсын Аллиер муж хоорондын хамтын ажиллагаа, хамтарсан гэрээ байгуулах үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2,432,150 (хоёр сая дөрвөн зуун гучин хоёр мянга нэг зуун тавь) төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

5223 11 0226

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 16 дугаар
сарын 16-ны өдрийн 2166 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Байрлах хоног	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	(төгрөгөөр)	
						Нийт дүн
1	Байрны зардал	2	4	153,000		306,000
2	Зочид төлөөлөгчийн хоолны зардал	2	5	132,375		529,500
3	Соёлын үйл ажиллагаа			708,050		708,050
4	Бусад зардал			888,600		888,600
	Дүн					2,432,150